



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН 2020 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2020 он

ТОВЪЁОГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 1.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан /хүснэгтээр/..... 3
- 1.2 Бодлогын баримт бичгийн дэлгэрэнгүй тайлан
- Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиллуулж, сургалтын чанар хүртээмжийг сайжруулна. 4-7
 - Төвд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох ажилтанд хариуцуулан үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэж, www.smartcity.mn цахим хуудсыг тогтмол хөтлөн ажиллуулна..... 8

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан /хүснэгтээр/..... 9-14

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

/Дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт/

- 3.1 Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ”.....15
- 3.2 Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг, эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвөлгөө өгч, оролцоог нэмэгдүүлнэ /Дүрмийн 2.3/.....16
- 3.3 Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн нэрэмжит уран зураг, гар урлал, монгол уран бичлэг, техник технологийн тэмцээн уралдаан үзэсгэлэнг улс, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулна.....16-19
- 3.4 Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулна. /Дүрмийн 2.6/..... 20-21
- 3.5 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг санаачлан зохион байгуулж, төвийн үйл ажиллагааг сурталчлан өргөжүүлнэ..... 22-25
- 3.6 Төвийн дугуйлангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшил, уралдаан тэмцээнд оролцсон амжилт, идэвхи оролцоог дүгнэн шалгаруулж шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулна. /Дүрмийн 2.12/..... 25
- 3.7 Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослоос хамгаалах зорилгоор холбогдох мэргэжлийн хүмүүсээр сургалт зохион байгуулна..... 26
- 3.8 Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна. /Дүрмийн 2.15/..... 27-28
- 3.9 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд..... 29-34

3.10 Ажлын байрны болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон цаашдын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгана.....	34
--	----

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1 Төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, дугуйлангийн талаарх мэдээ мэдээллийг төвийн вебсайт, Фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллана.....	34-36
4.2 Хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллана.....	36
4.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.....	36
4.4 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлтийн байдал	36-37

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

“НЭГ ХОТ-НЭГ СТАНДАРТ” зорилтот жилийн ажлын хүрээнд.....	38-41
ДҮГНЭЛТ.....	42

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН /ХҮСНЭГТЭЭР/

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь	Дэлгэрэнгүй тайлбар
				Он	Түвшин				
1	2	3	4	5	6	7	8	9	10
4.5.3 Монголын Хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төвийн салбар дугуйлангуудыг алслагдсан дүүрэг, хороодод ажиглуулах, хувийн хэвшлийн сургалтын төвийн секц, дугуйланг дэмжих замаар хүүхдийн авьяасыг хөгжүүлж, секц дугуйланд хамрагдалтыг 30 хувь нэмэгдүүлнэ.	4.110 Нийслэлийн алслагдсан дүүрэг, хороодод төвийн салбар дугуйланг ажиглуулж сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.110 Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиглуулж, сургалтын чанар хүртээмжийг сайжруулна.	Дугуйланд хамрагдах хүүхдийн тоо	2019	2079	2100	2100	100%	-
			Салбар дугуйлан, тоо	2019	9	12	12	100%	
Иргэдийн өргөдөл, гомдлыг хороодоор болон хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэддээ ил тод, нээлттэй шийдвэрлэнэ.		Төвд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох ажилтанд хариуцуулан үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэж, www.smartcity.mn цахим хуудсыг тогтмол хөтлөн ажиглуулна		2019	19	-	12	100%	-

1.2 БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

1.2.1 “Нийслэлийн алслагдсан дүүрэг хороодод төвийн салбар дугуйланг ажиллуулж, сургалтын чанар хүртээмжийг сайжруулна” зорилтын хүрээнд:

2020-2021 оны хичээлийн жилд Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран нийслэлийн эрсдэлт бүлгийн хүүхэд багачуудыг сурган хөгжүүлэх зорилгоор “Би нар” төслийг хэрэгжүүлж, Уран зураг, Монгол уран бичлэгийн 8 салбар дугуйлан мөн алслагдсан дүүрэг хороодын хүүхэд багачуудыг оршин суугаа газарт нь суралцах боломжоор хангах 4 салбар дугуйлангуудыг байгуулж нийт 12 салбараар сургалт явууллаа.

Эдгээр дугуйлангуудад 300-350 хүүхэд хамрагдсан.

2020 оны 11-р сарын 11-ны өдрөөс Ковид-19 цар тахлын улмаас МУЗГ-аас Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан сургалтын үйл ажиллагаа зогсоосон болно. Үүнд:

1. Хан-Уул дүүрэг 114 дүгээр сургуульд Уран зургийн дугуйлан /29 хүүхэд/



2. Хан-Уул дүүрэг 60 дугаар сургуульд Монгол уран бичлэгийн дугуйлан /40 хүүхэд/



3. Баянзүрх дүүрэг 111 дүгээр сургуульд Уран зургийн дугуйлан /31 хүүхэд/



4. Баянзүрх дүүрэг 19-р хороонд байрлах “Хөгжлийн хэлхээ” асрамжийн газар /14 хүүхэд/



5. Баянгол дүүрэг 6-р хороонд Иргэний танхим Монгол уран бичлэг /38 хүүхэд/



6. Чингэлтэй дүүрэг 16-р хороонд Уран зургийн дугуйлан /15 хүүхэд/



7. Чингэлтэй дүүрэг 9-р хороонд Уран зургийн дугуйлан /13 хүүхэд/



8. Чингэлтэй дүүрэг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс /29 хүүхэд/



9. Сүхбаатар дүүрэг 8-р хороо Иргэний танхим /20 хүүхэд/



10. Баянгол дүүрэг “ Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төв” /46 хүүхэд/



11. Сонгинохайрхан дүүрэг 9-р хорооны иргэний танхим /19 хүүхэд/



12. Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад Уран хайчилбарын дугуйлан /26 хүүхэд/



1.2.2 “Иргэдийн өргөдөл, гомдлыг хороодоор болон хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, иргэддээ ил тод, нээлттэй шийдвэрлэнэ” заалтын хүрээнд:

Төвд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох ажилтанд хариуцуулан үүссэн асуудлыг шуурхай шийдвэрлэж, www.smartcity.mn цахим хуудсыг тогтмол хөтлөн ажиллууллаа.

2020 онд www.smartcity.mn цахим хуудаст өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй ба төвийн захиргаанд бичгээр 12 хүсэлт ирсэн байна. Нийт ирсэн хүсэлтийг цаг тухайд нь хариу өгч 100% шийдвэрлэж, www.smartcity.mn цахим хуудсыг тогтмол хөтлөн ажиллуулж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Манай төв удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэрийг тогтмол үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ	Шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
1.а. Монгол Улсын хууль					
	9, 27.1, 31	Төрийн албаны тухай хууль	Төрийн албаны зарчмыг баримтлан хууль тогтоомжид заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.	-	-
	16.5	Төсвийн тухай хууль	2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 910,841,784 орлогоос 614,430,782 296,411,002 төгрөгийн үлдэгдэлтэй өглөг авлаггүй ажиллаж байна.	-	-
	6, 7	Шилэн дансны тухай хууль	Хуулиар тогтоосон хугацаанд https://shilendans.gov.mn/org/4315 сайтад мэдээллийг тогтмол байршуулж байна.	-	-
	5	Хөдөлмөрийн тухай хууль	Хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж, ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр ханган ажиллаж байна.	-	-
	6	Хүүхэд хамгааллын тухай хууль	Хуульд заасны дагуу “Хүүхэд хамгааллын төлөвлөгөө” гаргасан.	-	-
	7, 8, 9	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	http://huuhdiinurlan.ub.gov.mn/ сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	-	-
	7, 12, 13, 14, 15, 16	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль	Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу хугацаанд нь шийдвэрлэж, улирал бүр тайлан гаргаж байна.		

	22.1, 23.1, 24.2, 34	Гамшгаас хамгаалах тухай хууль 2017-02-02	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрх, үүргийнхээ хүрээнд Мэргэжлийн ангийн бүтэц, зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарь, хариу арга хэмжээний нөөц хангалтын тооцоог гарган “Коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг 11 дүгээр сарын 13-нд тус тус боловсруулж Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж мөрдөн ажиллаж байна.		
1.б. Улсын их хурлын тогтоол					
51	1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016_51	Нийслэлийн Засаг Даргын 2018.03.23-ны өдрийн А/237 дугаар захирамжаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мөрдөн ажиллаж байна.	-	-
			1. Төвийн багш, албан хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхолтой холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй болно. 2 Авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах утсыг тогтмол ажиллуулж байна. Ямар нэгэн мэдээлэл ирээгүй болно. 3. Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг төвийн цахим хуудас болон фэйсбүүк хуудаст тогтмол мэдээлж байна. 4. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу http://shilendans.gov.mn/org/4315 сайтад байгууллагын төсөв, гүйцэтгэлийн мэдээг тогтмол оруулж байна.		
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
				-	-
1.е. Засгийн газрын тогтоол					

276	1	Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 2019-07-03 Дугаар 276	Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн ажилтан, албан хаагчдын албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосон.	-	-
30	10	Шинэ коронавирус ийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-26 Дугаар 30	Монгол Улсын Засгийн газрын 30 дугаар тогтоолын 10 дугаар зүйлд заасны дагуу ажилтан албан хаагчийн өргөдөл, холбогдох бичиг баримтыг үндэслэн 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөөг олгосон.	-	-
258	1.2, 1.3, 1.7, 1.8, 1.9, 1.10	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, иргэдийг ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш, зөв шударга харьцан ажиллаж байна. 1.3. Ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор төвийн багш, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг дахин боловсруулсан. 1.7. Ажлын байранд ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа хэрэглэхийг хориглож, төвийн багш, албан хаагчдыг дотоод журмаа мөрдөн ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна. Одоогоор зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно. 1.8. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төвийн гадна талбайд суурилуулсан камерийн ажиллагааг хянаж, шаардлагатай үед засвар үйлчилгээг хариуцсан ажилтан хийж байна. 1.9. Ажлын цаг ашиглалтыг хяналтын камер, цаг бүртгэлийн төхөөрөмж ашиглан жижүүрийн бүртгэлээр баталгаажуулан хяналт тавин ажиллаж байна.	-	-
430		МУЗГ тогтоол 430	Манай байгууллагатай холбогдох худалдан авах үйл ажиллагаа хөрөнгө оруулалт хийгдээгүй, мөн 2020 онд төлөвлөгөө байхгүй болно.		

106		МУЗГ 106 дугаар тогтоол	МХУБТ нь улсын үзлэгээр 88,6% В үнэлгээ авсан бөгөөд өгсөн зөвлөмжийн дагуу ажлын хэсэг байгуулж сар улирал жилээр тайлагнан ажиллаж байна.		
1.ж. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл					
16	ХҮ.2.	2018 оны 4 сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 Дугаар 2018_16	Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг хяналтын камер, цаг бүртгэлийн төхөөрөмж ашиглан жижүүрийн бүртгэлээр баталгаажуулан хяналт тавьж байна. Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	-	-
21	XXIX. 2.4.	2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2019-05-16 Дугаар 2018_21	Хөдөлмөрийн зөрчил гаргасан ажилтан Л.Сэнгэдоо, Уран зургийн багш Д.Ганболд, жижүүр Н.Эрдэнэцогт нарт Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг үндэслэн сахилгын шийтгэл ногдууллаа.	-	-
36	XIY.1.	2018 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2018-08-29 Дугаар 2018_36	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуульд заасан хугацааны дотор хариу өгч шийдвэрлэж байна.	-	-
1.и. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол					
81	2.1, 3.5.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөр 2018-06-06 Дугаар 81	- Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй таатай орчин бүрдүүлэх чиглэлээр хийгдэх ажлын төсвийг 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдөр гаргасан. 2021 оны төсвийн төсөөлөлд дахин тусгахаар төлөвлөн ажиллаж байна. - Ариун цэврийн өрөө бүрт гар хатаагч суурилуулсан.	-	-
1.к. Нийслэлийн Засаг Даргын Захирамж					
A/108	1.6	“Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний	Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж тайланг Zendmaal@gmail.com цахим хаягт долоо хоног бүрийн Пүрэв гарагт илгээн ажиллаж байна.	-	-

		тухай” 2020-01-20 Дугаар 34			
A/168	1, 3,4	Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай 2020-02-07 Дугаар A/168	Захирамжийн биелэлтийг ханган ажиллаж 14 хоног бүрийн Баасан гарагт хийсэн ажлын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст илгээн ажиллаж байна.	-	-
A/191	2.1, 2.2	Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-02-13 Дугаар A/191	- Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн Захирлын зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар “Коронавирусын ээрсдэлээс урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын төлөвлөгөө”-г баталсан. - Монголын Хүүхдийн урлан Бүтээх төв”-ийн хариуцлагатай жижүүр”-ийн хуваарийг гарган мөрдөн ажилласан.		
A/223		Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай	- A/108 захирамжийн хэрэгжилтийн хугацааг сунгасантай холбогдуулан тайланг хугацаанд нь Zendmaal@gmail.com цахим хаягт долоо хоног бүрийн Пүрэв гарагт илгээн ажилласан. - Эргүүлээр ажиллаж байгаа албан хаагчдад тус захирамжийг танилцуулж, эргүүлээр ажиллахдаа Сонгинохайрхан дүүргийн 3,4-р хороодын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн баар, спорт соёл урлагийн газар, дэн буудлын үйл ажиллагаанд хяналт тавихыг үүрэг болгон эргүүлийн мэдээнд тусган ажилласан.		
A/268	1.2	12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай 2020-02-28 Дугаар A/268	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 сарын 28-ны өдрийн A/268 дугаар захирамжийн биелэлтийг ханган 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын 1 цагаар хорогдуулан, энэ зохицуулалтад хамрагдаж байгаа ажилтан, албан хаагчдын албан үүргийг бүрэн гүйцэтгүүлэн ажиллуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулан цалин хөлсийг ажилласанд тооцож олгосон.	-	-

747		A/747 Шагнаж урамшуулах 2020-05-28	Захирамжийн хэрэгжилтийг хангаж шалган нэвтрэх товчоодод 24 цагаар ажиллаж СХД 3,4 дүгээр хороодод өдрөөр эргүүлээр ажилласан албан хаагчдыг урамшуулж ажиллалаа.		
1037		A/1037 Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах арга хэмжээний 2020-08-14	Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар төвийн багш ажилчдад тээврийн хэрэгслийг улсын дугаараар ялгаж замын хөдөлгөөнд оролцуулах цагийн бүсчлэлийг танилцуулж тээрийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох тухай журмыг мөрдлөг болгон ажиллаа.		
1241		A/1241 Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 2020-11-11	A/1241 дүгээр захирамжийн дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч 0-12 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийг цалинтай гэрээр ажиллуулах тухай төвийн захирлын Б/43 тоот тушаал гаргаж, цаг бүртгэлийг хурууны хээ уншигчаар бүртгэлгүй er.ilaanbaatar.mn цахим бүртгэлээр бүргүүлж байхаар зохион байгуулж ажиллаа.		
1242		A/1242 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний 2020-11-12	Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан зөвшөөрөгдсөн 13 төрлийн байгууллага ажиллах бөгөөд МХУБТ нь тухайн 13 төрлийн байгууллагад хамаарахгүй тул бүх ажилчдыг гэрээс ажиллуулан цаг бүртгэлийг er цахим цаг бүртгэлээр цагаа бүртгүүлэн ажиллаж байна. Мөн нэн шаардлагатай 24 цагийн Сантехникийн слесарь болон жижүүрүүдэд албан тодорхойлолт гарган ажиллуулав.		
1280		НЗД А/1280 Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний 2020-12-21	A/1280 дугаар захирамжаас Монголын хүүхдийн урлан бүтээх төвд хамаарал бүхий 0-6 настай хүүхэдтэй ганц бие эцэг болон эхчүүдийг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлөөр хангаж ажиллаж байна.		

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

/Дүрмээр хүлээсэн чиг үүрэг/

Хүүхдийн Урлан Бүтээх төв нь хүүхэд багачуудыг амьдралын арга ухаанд сургах, хөдөлмөр гоо зүйн мэдлэг олгох, Монгол үндэсний өв соёл, уламжлалыг сурталчлан таниулах, хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгын хүрээнд 2020 онд захиргаа, аж ахуй үйлчилгээний албанд 30, сургалтын албанд 24 нийт 54 багш, албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа зохион байгуулж төрийн үйлчилгээг хүргэж байна.

3.1 Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ”

2020-2021 оны хичээлийн жилд нийт 16 төрлийн 24 дугуйланд 2100 хүүхэд суралцаж байна.

Төвийн дугуйлангийн сургалтын үйл ажиллагааг магистр, бакалаврын зэрэгтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай 24 уран бүтээлч багш нар удирдаж, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах, сургалтанд шаардлагатай хичээлийн хэрэглэл, хэрэглэгдхүүн хийц бэлтгэлийг хангах ажлыг мэргэжлийн туслах ажилчид гүйцэтгэж байна.

2020-2021 оны хичээлийн жилд төвд суралцагч хүүхдүүддээ зориулан Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвөөс анхан, дунд, гүнзгий шатны сурах бичгийг эрхлэн гаргаж сургалтын үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна.



3.2 Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг, эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвөлгөө өгөх, оролцоог нэмэгдүүлнэ /Дүрмийн 2.3/

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв нь 2020-2021 оны хичээлийн жилд эцэг эхчүүддээ зориулсан “Хамтдаа Хөгжье” нээлттэй хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 10 дугаар сарын 07-нд Монголын шувуулахуйн холбоотой хамтран Монголын биет бус өв болох шонхор шувууны талаар сонирхолтой мэдээлэл өгч, түүнийг хэрхэн зурах тухай арга ажиллагааг уран зургийн багш М.Энхбаяр заалаа.



3.3 Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн нэрэмжит уран зураг, гар урлал, монгол уран бичлэг, техник технологийн тэмцээн уралдаан үзэсгэлэнг улс, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулна.

Монголын хүүхдийн урлан бүтээх төв “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан дэлхий нийтэд тархсан цар тахалын халдварын үед ард иргэдийнхээ төлөө шаргуу ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтанууд, хүүхдийн төлөө сайн үйлстэнг алдаршуулах, хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, танин мэдэхүйг хөгжүүлэх, чөлөөт цагийг бүтээлчээр өнгөрүүлэх зорилгоор "БАЯРЛАЛАА AVENGERS" хүүхдийн зургийн уралдааныг зохион байгууллаа.

Тус уралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд Нийслэлийн ЕБС болон Налайх, Багануур, Архангай, Өвөрхангай, Дорнод, Увс, Дорноговь,

Орхон, Сүхбаатар, Төв зэрэг аймгуудаас нийтдээ 330 бүтээл оролцож шагналт байранд 20, шилдэг 80 нийт 100 бүтээлийг тодрууллаа.

Уралдааны шагнал гардуулах ёслол 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж шилдгүүдээ шагнаж урамшуулав. “БАЯРЛАЛАА AVENGERS” гар зургийн уралдаан нь олон нийтийг өргөн хамарсан үйл ажиллагаа болсон бөгөөд дараах хэвлэл мэдээллийн алба, сайтуудад мэдээлэл нь онцлогдож тавигдсан. Үүнд: <http://sainmedee.mn>, <https://nuur.mn/>, <http://tovchoo.mn>, <https://eguur.mn/>, [Эрүүл Мэндийн Яам, https://www.montsame.mn/](http://www.montsame.mn/), [Mass TV](http://MassTV.mn), Zogii.mn



Уушгины хатгалгаатай тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан хүүхэд багачуудыг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд өсгөх, сурган хүмүүжүүлэх, баяр хөөртэй амар амгалан байлгах, чөлөөт цагийг нь зөв зохистой бүтээлчээр өнгөрүүлэх зорилгоор дүрслэх урлагаар дамжуулан хүүхэд багачуудыг уушгины хатгалгаа өвчнөөс сэргийлэх, хүүхдийн өвчлөлийг бууруулахад эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, танин мэдэхүйг хөгжүүлэх, оюуны бүтээлийг дэмжих хөгжүүлэхээр Эх Хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран “ЦЭВЭР АГААР-ЭРҮҮЛ УУШГИ” зургийн уралдааныг зохион байгууллаа.

Уралдааныг бага нас 1-5-р анги, дунд нас 6-9-р анги ангилалаар зохион байгуулж хөдөө орон нутаг болон Нийслэлийн ЕБС-иас нийтдээ 200 бүтээл оролцож шилдэг 6 бүтээлийг тодруулав.



Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 10-р сарын 1-31-ний өдрүүдэд орон даяар өрнүүлж байгаа “Хамтдаа хамгаалъя” аяны хүрээнд ЕБС-ийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг Стратеги академитай хамтран зохион байгууллаа.

“Хамтдаа хамгаалъя” гар зургийн уралдаанд 340 хүүхэд оролцож шилдэг 9, тусгай байрны 54 хүүхдийг шалгаруулж шагнаж урамшуулав. Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа 11 сарын 01-ны өдөр Norphei Art Gallery-д -д амжилттай болж өндөрлөлөө.



3.4 Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулна. /Дүрмийн 2.6/

Монгол улс, Бүгд Найрамдах Энэтхэг улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойд зориулан хоёр орны эртнээс улбаатай найрсаг харилцаа, эх түүх, соёл иргэншил, найрсаг харилцааг Монгол хүүхэд багачуудад сурталчлан таниулах, хоёр улсын өнгөрсөн болон өнөө, ирээдүйг хүүхэд багачуудаар дамжуулан харах, тэдний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, оюуны бүтээлийг дэмжих замаар хоёр орны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн өргөжүүлэх зорилгоор БНЭУ-с Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Улаанбаатар хот дахь Энэтхэгийн соёлын төв, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв хамтран Монгол улсын Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн уран зураг, гар урлалын наадмыг зохион байгуулж, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа боллоо.



Монгол Энэтхэг улсын “ӨНГӨРСӨН-ОДОО-ИРЭЭДҮЙ” гар урлал, уран зургийн наадамд Нийслэлийн ЕБС болон хөдөө орон нутгийн 976 хүүхэд бүтээлэрээ оролцож шилдэг 25 хүүхдийг шагнаж урамшууллаа.



Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монголын Хүүхдийн урлан бүтээх төв хамтран “МИНИЙ МЭДЭХ СОЛОНГОС ОРОН”

гар урлал, уран зургийн үзэсгэлэн, наадмын нээлтийн арга хэмжээ 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн “Орд” арт галерейд зохион байгууллаа.

Нээлтийн үйл ажиллагаанд урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ли Ё Хун, Элчин сайдын яамны 1-р нарийн бичгийн дарга Пак Ын Жон, 3-р нарийн бичгийн дарга, Консул Жон Гу Ын, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга н.Батбаатар оролцлоо.

“Миний мэдэх Солонгос орон” гар урлал, уран зургийн үзэсгэлэнд Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиуд болон Архангай, Өвөрхангай, Дорнод, Говьсүмбэр, Увс, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар, Сэлэнгэ, Баян-өлгий, Эрдэнэт, Өмнөговь зэрэг хөдөө орон нутгийн хүүхдүүд идэвхтэй оролцсон. Тус үзэсгэлэн, уралдаанд 1250 хүүхдийн бүтээлийг ахлах, дунд, бага насны ангиллаар гар урлал, уран зураг гэсэн 2 төрлөөр шалгаруулж шагнал байранд 25, шилдэг 300 бүтээлийг тодруулж Элчин сайдын яамнаас бэлэг гардууллаа.



3.5 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг санаачлан зохион байгуулж, төвийн үйл ажиллагааг сурталчлан өргөжүүлнэ.


Алслагдсан хороодын хүүхдүүдэд сурч хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн хүмүүжил төлөвшил олгох боломжийг өргөжүүлэх зорилготойгоор Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Монголын хүүхдийн урлан бүтээх төв хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичгийг байгууллаа.



Худалдаа хөгжлийн банкнаас санаачлан хэрэгжүүлсэн “Хязгааргүй мөрөөдөл” аяны хүрээнд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд шинээр хүүхдийн номын сан байгуулж, төвийн багш нар номын сангийн өрөөг шинээр засварлаж тохижуулав.



“Монголын Хүүхдийн Үндэсний Кино Академи”-тай хамтран “Бүтээлч хүүхэд” 24 цуврал нэвтрүүлгийг санаачлан хийж, төвийн 18 багш оролцон хүүхэд багачуудад дүрслэх урлаг, гар урлалын хичээл заалаа. Тус нэвтрүүлэг нь Даваа-Баасан гарагийн 14 цагаас UBS телевиз болон олон нийтийн цахим сүлжээгээр цацагдсан. Мөн МХУБТ-ийн www.huuhdiinurlanubgov.mn цахим хаяг, төвийн нүүр хуудсаар алсын зайн сургалтын цуврал хичээл болгон хүүхдүүддээ тогтмол хүргэж байна.



Дархан-Уул аймгийн Хонгор сумын тариалангийн талбайгаас төвийн сүрлэн урлалын ангиудын сургалтад зориулан сүрэл бэлтгэх ажлыг хамт олноороо зохион байгууллаа.



Дархан-Уул аймгийн Хонгор сумын Ерөнхий Боловсролын 14 дүгээр сургуулийн сурагчдад танин мэдэх, хөдөлмөр гоо зүйн мэдлэг олгох зорилгоор сүрлэн сүлжмэл, уран зургийн сургалтыг зохион байгууллаа.



Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2012 оноос эхлэн жил бүрийн 10-р сарын 11-ний өдрийг Олон Улсын Охидын өдөр болгон тунхагласантай холбогдуулан 10 дугаар сарын 11-ний өдөр “Ээж охидын өдөрлөг” зохион байгууллаа

Өсвөр насны охидод тулгамддаг асуудалд зөвлөгөө өгөх, эх үрсийг хөгжүүлэх зорилгоор “Ээж дэлхий бүсгүйчүүдийн цахим нэгдэл”, “Алдарт эх” групп, Эмэгтэйчүүдийн дотоод гоо сайхны “Ла Сантэ” эмнэлэгтэй хамтран “Ээж, охидын өдөрлөг”-ийг 01 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Өдөрлөгт 100 гаруй одонтой ээжүүд охидтойгоо оролцсон.



3.6 Төвийн дугуйлангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшил, уралдаан тэмцээнд оролцсон амжилт, идэвхи оролцоог дүгнэн шалгаруулж шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулна. /Дүрмийн 2.12/

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн “Шилдэг хүүхэд” шалгаруулах журмын 3 номинацаар Баярбатын Мөнххүслэн, Батнасангын Зэсмаа, Дамдинсүрэнгын Түвшинбаяр нарыг шалгаруулж Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн “Оны шилдэг сурагч” өргөмжлөл, тууз болон дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав.



3.7 Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослоос хамгаалах зорилгоор холбогдох мэргэжлийн хүмүүсээр сургалт зохион байгуулна.

ДЭЛХИЙН ГАР УГААХ ӨДӨР-ийн хүрээнд төвийн эрүүл мэндийн арга зүйч, нийгмийн ажилтан хамтран дугуйлангийн хүүхэд багачуудад “Гараа хэрхэн зөв угаах аргачлал” зааж зөвлөмж тараан өгөв.



“ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН” “гэдэсний халдварт өвчин, ахуйн хүрээний осол гэмтлээс сэргийлэх тухай сургалтыг СБД-ийн 6 хорооны Сайн наран өрхийн эмнэлгийн нийгмийн ажилтан Нармандах анхан шатны дугуйлангийн сурагчдад зохион байгууллаа. Мөн “ТАМХИНЫ ХОР ХӨНӨӨЛ”, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, Өсвөр үеийхэний онцлог, тэдэнд тулгарч буй асуудлууд, сэтгэл зүйн байдал нөхөн үржихүйн асуудал зэрэг сэдэвт сургалтыг төвийн дунд, ахлах ангийн сурагчдад сургалт хийлээ.



Хүүхэд хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд төвийн дугуйлангийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 хүртэлх насны 1-5 дугаар ангийн 893 хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, багш, эцэг, эх, асран хамгаалагчдад 10 хүртэлх насны хүүхдээ “Гараас гарт” хүлээлгэн өгөх ажлыг тусгай журмаар зохицуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхэд болон явган зорчигчийг аюулгүй гарцаар гарах нөхцлийг бүрдүүлж Урлан бүтээх төвийнхөө орчимд “СУРГУУЛЬ ОРЧМЫН БҮС” тэмдэглэгээг 2 талдаа байршуулж ажиллаа.

3.8 Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна.” заалтын хүрээнд: /Дүрмийн 2.15/

Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны Хэрэг Эрхлэх Газраас зохион байгуулж буй ерөнхий боловсролын сургуулийн 13-18 насны сурагчдын дунд гар зураг, постерийн олон улсын уралдааны удирдамжийг багш нарт танилцуулж сурагчдаа идэвхтэй оролцуулах талаар чиглэл өгч ажиллаа.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн багш нарын “Art&Graft” шилдэг уран бүтээлийн үзэсгэлэн 2020 оны 01 дүгээр сарын 24-нд зохиогдлоо. Тус үзэсгэлэнд төвийн 24 уран бүтээлч багш 86 бүтээлээрээ оролцож, ардын урлаг, сонгодог урлаг, чимэглэх урлаг төрөлд шилдгүүдээ тодруулав.



Үзэсгэлэнгийн шүүгчээр ДУТС-ийн Дүрслэх урлагийн тэнхимийн профессор, урлаг судлалын ухааны доктор зураач Ц.Эрдэнэцог, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, Монголын Урчуудын Эвлэлийн хорооны зураач Ш.Чимэддорж нар ажиллаа.

Үзэсгэлэнг нээж Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирал Д.Уранбилэг, ДУТС-ийн Дүрслэх урлагийн тэнхимийн профессор, урлаг судлалын ухааны доктор зураач Ц.Эрдэнэцог, Монгол Улсын **Урлагийн гавьяат зүтгэлтэн**, Монголын Урчуудын Эвлэлийн хорооны зураач Ш.Чимэддорж нар үг хэллээ. Тус үзэсгэлэнгийн шагналт байранд:

- Ардын урлаг төрөлд-Уран хатгамалын багш С.Ганцэцэг /Даалин урлал бүтээл/
- Сонгодог урлаг төрөлд- Уран зургийн багш Д.Ганболд /Адуучин залуус бүтээл /
- Чимэглэх урлаг төрөлд- Анхан шатны уран баримлын багш Б.Ичинхорлоо /Дангина/ бүтээлүүд тус тус тодорлоо.



Үзэсгэлэнд төвийн дугуйлангийн сурагчдаас багш нартаа зориулж “Торгууд гоёо” бүжгээр мэндчилгээ дэвшүүллээ.



Төвийн багш албан хаагчдын ажлын байран дахь уялдаа холбоог сайжруулах, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, туршлага солилцох, хамт олны эерэг уур

амьсгалыг бий болгох зорилгоор “Алтан намар 2020” судалбар зургийн өдөрлөг зохион байгуулав.



3.9 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд:

Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах нэмэгдлүүдийг ажлын үр дүнд үндэслэн олгож байна. Мөн багш, албан хаагчдад хоол унааны зардлыг тогтмол олгож байна.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв нь 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын Шинэ Коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 30 дугаар тогтоолын 6 дугаар зүйлд заасны дагуу дугуйлангийн сургалт болон уралдаан, үзэсгэлэнгийн үйл ажиллагааг 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс бүрэн зогсоосон.

Томуу томуу төст өвчний тархалт болон шинэ "Коронавирус"-ийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага дээрээ байнга хэрэгжүүлэн ариун цэвэр халдваргүйжүүлэх арга хэмжээ аван өрөө тасалгаанд хлорамины уусмалтай цэвэрлэгээ хийж, ариун цэврийн өрөөнд шингэн саван, спиртэд суурилсан гар ариутгагч тавин ажиллаж ажилчдаа байнга эрүүл мэндийн яамны мэдээллээр хангаж, халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.

Ажилчдынхаа эрүүл мэндийг хамгаалах зорилгоор өдөр бүр биеийн халууныг хянаж байна.

Өндөржүүлсэн байдлын үед ариутгал халдваргүйжүүлэлтийн хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөц хангалтыг нэмэгдүүлж ажилчдын гар угаах боломжийг бүрдүүлэн шингэн саван, белизна болон ариутгалын бодисоор байнга ханган ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын А/268 дугаар захирамжийн дагуу 12 хүртэлх насны хүүхэдтэй 19 эхчүүдийг гэрээсээ ажиллах боломжоор ханган ажлаас чөлөөлж захирамжийн биелэлтийг хангаж ажиллаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэх өгөх тухай” 10 дугаар зарлиг, Томуу томуу төст өвчний тархалт болон шинэ "Коронавирус"-ийн

халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор төвийн ажилтан албан хаагчдад 120 ширхэг маск олголоо.

Төвийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих зорилгоор 3 төрлийн витаминаар сар бүр витаминжууллаа.



Төвийн багш албан хаагчдын хүүхдүүдэд цүнх, хичээлийн хэрэгсэл бэлэглээ.




Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлыг арилгах зорилгоор өглөө бүр ажлын байрны дасгал хөдөлгөөн, гимнастик хийж, 14 хоногт нэг удаа спорт зааланд биеийн тамирын өдөрлөг зохион байгуулан ажилласан.



Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгтэй хамтын ажиллагааны хүрээнд 2020 оны хичээлийн жилд бүх ажилчидаа эрүүл мэндийн шинжилгээнд үнэ төлбөргүй хамрууллаа. Мөн Self medic Mongolia эмнэлэгтэй хамтран ажиллаж, ажилтнуудаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулав.




Төвийн багш албан хаагчдын эрүүл мэндийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, эрүүл аж төрөх ёс, эко бүтээгдхүүн хэрэглэж хэвших, харилцан туршлага солилцох зорилгоор “Эко” хоолны өдөрлөгийг сар бүр зохион байгуулж хэвшсэн.





Ковид-19” цар тахлын үед иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх нөхцөл боломжоор хангах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн 6 хороо, “Line Dance” бүжгийн холбоотой хамтран зохион байгуулсан “ЭМГҮЙГЭЭР БҮЖГИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨР ЭРҮҮЛЖЬЕ” хөтөлбөрт байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж ажиллаа.



Төвийн ажилтан ажилчдын орон сууцны судалгааг үзвэл нийт 54 ажилчдаас орон сууцанд 27, хашаа байшин, гэрт 27 хүн үүнээс түрээсийн хашаа байшинд 1, эгчийн хашаанд 1 хүн байна.

Төвийн багш, албан хаагчдын сэтгэл зүйг дэмжих, ажиллах урам зориг, идэвхийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомж болон байгууллагын дотоод журмын хүрээнд зохих тэтгэмж, урамшууллыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.


Нийт багш ажилчид **44.813.000** төгрөгний нийгмийн халамж үйлчилгээг жилийн байдлаар үзүүлж ажилласан.

Хамт олоны фондоор нийт 8 ажилтанд эмнэлэгт хэвтэх, хагалгаанд орох , хүүхэд төрүүлэх, гэр бүлийн хүмүүсээс нь нас нөхөцсөн үед 2,777,000 төгрөгний тусламж үзүүлсэн.

Албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр:

№	Хамрагдсан сургалт	Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	Хугацаа
1	Монгол Улсын Боловсролын их сургуулийн боловсролын удирдлагын магистрын зэрэг олгох сургалт	Л.Атар – хүний нөөцийн ажилтан	2019-2020 05.20-06.25
2	МУИС-ийн Бизнесийн сургуульд Бизнес удирдлагын магистраар мэргэжил дээшлүүлэн суралцаж байна.	Уран хатгамалын багш	2020-2021
3	Олон Улсын Улаанбаатар Их Сургуульд Бизнесийн удирдлагаар магистр – Төрийн албан хаагчийн тэтгэлэг	Захиралын туслах	2019-2021

Төвийн нийт багш албан хаагчдын эрүүл мэнд, дасгал хөдөлгөөнийг сайжруулах зорилгоор багш, албан хаагчдад “Венийн Вальс” бүжгийн хичээлийг 2 сарын турш зохион байгууллаа.



Төвийн багш албан хаагчдын бие бялдар, эрүүл мэндийг дэмжих, хамт олны эв нэгдлийг сайжруулах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор спортын 4 төрлөөр Спорт өдөрлөгийг зохион байгууллаа. Манай байгууллагын Биен тамирын хамтлаг 2020 оны Нийслэлийн шилдэг хамтлагаар шалгарч шагнал хүртсэн.



Төрийн албаны тухай хуулийн шинэчлэл болон түүний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төвийн багш, албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүй сэдвээр Төрийн албаны төв зөвлөлийн Стратеги төлөвлөлт, бодлогын зөвлөх Д.Дэмчигсүрэн /PhD/-г урьж сургалт зохион байгууллаа.



3.10 Ажлын байрны болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцон цаашдын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгана.

Төвийн багш албан хаагчдаас ерөнхий 8 асуулгаас бүрдсэн ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг авлаа. Судалгаанд нийт 58 багш, албан хаагч оролцсоноос, ажлын байрны сэтгэл ханамж 90% буюу хангалуун байна.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн суралцагч хүүхэд багачууд, эцэг эхээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Тус судалгаанд нийт 1552 хүн хамрагдаж, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг SPSS программ дээр боловсруулан дүгнэлт гаргав. Дүгнэлтээр эцэг эх асран хамгаалагчдын хувьд тус төвийн явуулж буй үйл ажиллагаа хүүхэд багачууд олон нийтэд нээлттэй байдаг, сургалтын арга барил хүүхэд багачуудад таалагддаг гэж үнэлэгдэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 85,6% буюу В үнэлгээтэй байна


Тус судалгаан дээр үндэслэн цаашид хүүхдүүдийн сургалтын орчин, зарим анги танхимын ширээ сандлын хүрэлцээ, эрүүл аюулгүй байдал, тохижилтод анхааран ажиллана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, дугуйлангийн талаарх мэдээ мэдээллийг төвийн вебсайт, Фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллана.

Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй байлгах хүрээнд:

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй ажиллуулж, мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж байна.



“Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн багш нарын ART & CRAFT10” “Урлаг ба Урлахуй” шилдэг бүтээлийн уралдаан, үзэсгэлэнгийн мэдээллийг STAR TV, MNB монголын радио 106.0 FM радиод өгч ажиллалаа..

"БАЯРЛАЛАА AVENGERS" хүүхдийн зургийн уралдааныг МОНЦАМЭ, Нүүр.мн, Сайн мэдээ.мн, Товч.мн зэрэг пэйж, сайтуудаар сурталчиллаа.

Телевиз, радио, хэвлэл мэдээллийн байгууллагад өгсөн ярилцлага, мэдээ, нэвтрүүлгийн нэгдсэн товъёог

/Хүснэгтээр/

	Телевизийн нэр	Сар өдөр	Ямар сэдвээр	Мэдээлэл өгсөн нэр
1	Монгол телевиз HD	01/08	Төвийн дугуйлангийн сургалт, үйл ажиллагааны талаар	Анхан шатны дугуйлангийн багш Ц.Дуламсүрэн
2	Монгол телевиз HD	01/23	Уран зургийн дугуйлан, хувийн уран бүтээл, ажил амжилтын талаа	Уран зургийн дугуйлангийн багш Д.Ганболд
3	Зууны мэдээ сонин	02/03	Төвийн дугуйлангийн сургалт, арьсан урлалын талаар	Арьсан урлалын дугуйлангийн багш Э.Бямбасүрэн
4	Эко телевиз	06/01	Төвийн дугуйлангийн сургалт, үйл ажиллагааны талаар	Захирал Д.Уранбилэг
5	НАМЭХ блог	04/20	“Миний ажлын өрөөнд”	Захирал Д.Уранбилэг
6	UBS телевиз	04/20-06/20	“Бүтээлч хүүхдүүд” цуврал теле хичээл	Багш нар

Теле хичээл

- 2020 онд - 28

Ярилцлага, хэлэлцүүлэг

- 2020 онд - 8

Үзэсгэлэн уралдаан

- 2020 онд - 7

4.2. Хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллана.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн хүний нөөцийн ил тод байдлыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй ажиллуулж, мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж байна

Хүний нөөцийг удирдлагын ил тод байдал

№	Хүний нөөцийн нэр	Хүний нөөцийн ажил	Хүний нөөцийн амжилт	Хүний нөөцийн амжилтын өдөр
1	С.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
2	Д.Тогтоол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
3	С.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
4	Д.Салбаа	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
5	Г.Тогтоол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
6	Б.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
7	Б.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
8	С.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
9	Ш.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
10	Т.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
11	Т.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
12	Б.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
13	Б.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
14	Т.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр

Хүний нөөцийг удирдлагын ил тод байдал

№	Хүний нөөцийн нэр	Хүний нөөцийн ажил	Хүний нөөцийн амжилт	Хүний нөөцийн амжилтын өдөр
1	С.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
2	Д.Тогтоол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
3	С.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
4	Д.Салбаа	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
5	Г.Тогтоол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
6	Б.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
7	Б.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
8	С.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
9	Ш.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
10	Т.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
11	Т.Батбаяр	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
12	Б.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
13	Б.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр
14	Т.Монгол	Хүний нөөцийн ажил	2018.03.31	Байр

4.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.

Хуулиар тогтоосон хугацаанд https://shilendans.gov.mn/org/_4315 сайтад мэдээллийг тогтмол байршуулж байна.

<http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлын хүрээнд:

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 910,841,784 орлогоос 614,430,782 296,411,002 төгрөгийн үлдэгдэлтэй өглөг авлаггүй ажиллаж байна. **4.4 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлтийн байдал:**

4.4.1 Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглаж, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллана.

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захиргааны 12 албан хаагч www.edoc.ulaanbaatar.mn программыг ашиглаж, түүний хэрэгжилтэд албан хэрэг хөтлөлтийн ажилтан хяналт тавин ажиллаж байна.

2020 оны байдлаар:

	Албан бичиг	Нийт тоо	Үүнээс:	Шийдвэрлэлт
1	Ирсэн бичиг	139	58 хариутай	98.62%
			81 хариугүй	
2	Явсан бичиг	101	101 хариугүй	100%

4.4.2 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглана.

Төвийн нийт 54 багш, албан хаагчид www.erp.ulaanbaatar.mn программыг ашиглаж, түүний хэрэгжилтэд хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хяналт тавин ажиллаж байна.

4.4.3 Байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулж, цахим нөхөн бүрдүүлэлтийг тогтмол хийнэ.

Захирлын А, Б тушаалуудыг нөхөн бүрдүүлэлтээр цахим хуудаст оруулж, байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД


“НЭГ ХОТ-НЭГ СТАНДАРТ” зорилтот жилийн ажлын хүрээнд:

Нэг хот - Нэг стандарт зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж биелэлтийг ханган ажиллаж байна.

Байгууллагын албан хэрэг хөтлөлтөнд MNS 5140-1:2011, баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага MNS 5140-2:2011, баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих шаардлага MNS 5140-352011 стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Сургалтын болон ажлын байрны таатай орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах, стандартад нийцүүлэх, хүүхэд хөгжлийг дэмжих зорилгоор Хүүхдийн бүтээлийн галерейг шинэчлэн байгуулж, шаардлагатай анги танхим, хонгилууд, хийц бэлтгэлийн өрөө, лобарантын өрөө, гадна цэцэрлэгийн тохижилтуудыг 100% өөрсдийн нөөц бололцоо, хүч хөдөлмөрөөр хийж гүйцэтгэлээ. Мөн байгууллагын урд байрлах түүхэн хөшөө дурсгалыг засаж сайжрууллаа.

- Төвийн хонгилын засвар



- Хүүхдийн бүтээлийн галлерей нэг ба хоёрдугаар давхарт





- Анги танхимын тохижилт



- Лаборантын өрөөний засвар




- Хийц бэлтгэгчийн өрөөний засвар



- Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлт

Төвийн албан хаагчид гадна талбайн өнгө үзэмжийг сайжруулан цэцгийн мандал тарьж, их цэвэрлэгээ хийлээ.



- Хонгилын засвар



Мөн дугуйлангийн хүүхэд багачуудын суралцах орчныг сайжруулах зорилгоор төвийн 1 дүгээр давхрын коридор, хана ,шатыг шинэчлэн будаж, гэрэлтүүлэгээ сайжруулж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн ажиллаа.



- Хөшөө дурсгал, гадна талбайн тохижилт

2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд байгууллагын гадна талбайд тохижилт хийх, орчин тойрныхоо ногоон байгууламжийг цэцэгжүүлэх услах, гадна талбайн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, тохижуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: хөшөө засах, будах, сандал, хогийн

савнуудыг угаах, засах, будах, цэцгийн мандлыг засах, зүлэг, цэцэг тарьж ургуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



ДҮГНЭЛТ

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв нь 2020-2021 оны хичээлийн жилд “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” эрхэм зорилго дэвшүүлэн Монгол уран зураг, Монгол хувцас дизайны ангийг шинээр нээж 16 төрлийн 24 дугуйланд нийт 2100 хүүхдийг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр үнэ төлбөргүй сурган хөгжүүлж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажилагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын батлагдсан төсвийг зүй зохистой зарцуулан, төсвийн хэмнэлт гаргаж өр төлбөргүй ажиллаа.

2020 онд дэлхий нийтэд тархаад байгаа COVID19 шинэ төрлийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын болон Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Засгын газар, Улсын Онцгой Комисс, Нийслэлийн Засаг даргын захирамж болон холбогдох тушаал, шийдвэрүүдийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН _____ /Л.АТАР/

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ _____ /Д.УРАНБИЛЭГ/